



СЭЛЭНГЭ АЙМАГ
БАЯНГОЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 28 өдөр

Дугаар A/118

Баруун хараа

Газар эзэмшүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "Г" дэх заалт, 31 дүгээр зүйлийн 31.1.4 дэх заалт, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалт, Газрын хэвллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.2 дахь заалт, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалт, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2018 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 57 тоот албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Ашигт малтмалын хайгуулын XV-020950 тоот тусгай зөвшөөрлийн талбайд хайгуулын үйл ажиллагаа явуулах зорилгоор хайгуулын гэр кемп байгуулах газар олгох хүсэлт ирүүлснийг судалж үзээд Нарийн хөндийд байрлах доорхи солбицпол бүхий

д/д	Газрын байршил	Уртраг	Өргөрөг
1	Нарийн хөндий	106° 07' 16.1"	48° 45' 48.5"
2		106° 07' 28.8"	48° 45' 50.8"
3		106° 07' 33.7"	48° 45' 37.2"
4		106° 07' 22.1"	48° 45' 33.9"

нийт 12 га газрыг хайгуулын гэр кемпийн газрын зориулалтаар эзэмших эрхийг улсын бүртгэлийн 1311013130, регистрийн 3753603 дугаартай Сэлэнгэ байгалийн нөөц ХХК-д 5 жилийн хугацаатайгаар олгосугай.

2. Газар эзэмшигч Сэлэнгэ байгалийн нөөц ХХК-ийн захирал /Ч. Энхбаатар/-д даалгах нь:

а/ Ашигт малтмалын тухай хуулинд заагдсан ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүргийг олгогдсон эзэмшлийн газарт бүрэн хэрэгжүүлж ажиллах

б/ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн холбогдох заалтын дагуу ерөнхий үнэлгээг хийлгүүлж байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулах

в/ Холбогдох хуулийн дагуу газар, ус ашигласны төлбөр тооцоог барагдуулах

г/ Байгаль орчныг хамгаалах дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх зэрэг асуудлаар гэрээ байгуулан ажиллах

3. Газар эзэмшүүлэх ажлыг баталгаажуулж, гэрээ байгуулж, гэрчилгээжүүлж, бүртгэл мэдээллийг хөтөлж ажиллахыг газрын даамал /Г. Саранцэцэг/-т үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг байгаль орчны хяналтын улсын байцаагч /М. Бумцэнд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С. АРИУНБАТ